

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



“МӨНГӨ НӨӨЦ БАЯЛАГ АУДИТ” ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Баян-Өндөр сумын Эгшиглэн Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ОРА-2022 /76/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Орхон аймаг 2022 он	Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах Утас: 7035 9826 Цахим хаяг: orkhon@audit.gov.mn Аудитын менежер: Б.Эрдэнэ Утас: 7035 8505 Цахим хаяг: orkhon@audit.gov.mn Аудитор: З.Баттуяа Утас: 99550516 Цахим хаяг: mnbaudithhk@gmail.com
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан (төгрөгөөр).....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3.Аудитын тайлан.....	8
3.1 Ерөнхий зүйл.....	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4. Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт	15
4.1 Залруулсан алдаа	15
4.2 Төлбөрийн акт	15
4.3 Албан шаардлага	15
4.4 Зөвлөмж.....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	Error! Bookmark not defined.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Олон Улсын Стандарт
СХДАА	Санхүүгийн Хяналт Дотоод Аудитын Алба
БСУГ	Боловсрол Соёл Урлагийн Газар



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.02.05 № 57
танай _____-ны № _____-т

**ОРХОН АЙМГИЙН БАЯН-ӨНДӨР
СУМЫН ЭГШИГЛЭН СОЁЛЫН
ТӨВИЙН ЭРХЛЭГЧ
Б.БУЯНЖАРГАЛ ТАНАА**

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эгшиглэн соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эгшиглэн соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	24,533,391.50	24,533,391.50
33	АВЛАГА	1,310,000.00	1,310,000.00
335	Бусад авлага	1,310,000.00	1,310,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	1,310,000.00	1,310,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	23,223,391.50	23,223,391.50
351	Түүхий эд материал	22,383,875.00	22,383,875.00
35110	Тусгай зориулалттай материал	22,383,875.00	22,383,875.00
354	Хангамжийн материал	839,516.50	839,516.50
35420	Аж ахуйн материал	839,516.50	839,516.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	81,002,344.55	77,150,499.47
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	81,002,344.55	77,150,499.47
392	Биет хөрөнгө	19,787,344.55	15,935,499.47
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	37,893,158.00	37,893,158.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(31,364,151.91)	(34,574,096.95)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	16,933,600.00	16,933,600.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(12,491,966.74)	(13,133,866.78)
39217	Ном	8,816,705.20	8,816,705.20
393	Биет бус хөрөнгө	61,215,000.00	61,215,000.00
39301	Программ хангамж	175,000.00	175,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(175,000.00)	(175,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	61,215,000.00	61,215,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	105,535,736.05	101,683,890.97
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	105,535,736.05	101,683,890.97
51	Засгийн газрын хувь оролцоо	105,535,736.05	101,683,890.97
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	129,007,587.00	129,007,587.00
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	129,007,587.00	129,007,587.00
512	Хуримтлагдсан үр дүн	(32,670,822.31)	(36,522,667.39)
51210	Өмнөх үеийн үр дүн	(32,670,822.31)	(32,670,822.31)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(3,851,845.08)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	9,198,971.36	9,198,971.36
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	105,535,736.05	101,683,890.97

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	112,707,100.00	136,613,200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	462,000.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	100,000.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	100,000.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	100,000.00	-
122	Тусламжийн орлого	362,000.00	-
122001	Хандив тусламж /дотоод/	362,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	112,245,100.00	136,613,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	112,245,100.00	136,613,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	112,245,100.00	136,613,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	114,727,046.52	140,465,045.08
21	УРСГАЛ ЗАРДАЛ	114,727,046.52	140,465,045.08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	105,511,345.03	106,947,628.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	68,998,405.85	69,476,925.00
210101	Үндсэн цалин	68,818,005.85	69,234,525.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	180,400.00	242,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,914,692.66	9,320,068.02
210201	Тэтгэврийн даатгал	6,167,262.45	6,552,347.06
210202	Тэтгэмжийн даатгал	689,984.02	693,699.32
210203	ҮОМШӨ-ний даатгал	551,987.22	554,959.44
210204	Ажилгүйдлийн даатгал	125,490.93	131,663.78
210205	Эрүүл мэндийн даатгал	1,379,968.04	1,387,398.42
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,240,000.00	21,240,000.00
210301	Гэрэл, цахилгаан	348,000.00	1,798,900.00
210302	Түлш, халаалт	20,892,000.00	19,180,000.00

210303	Цэвэр, бохир ус	-	261,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	568,200.00	645,400.00
210401	Бичиг хэрэг	105,000.00	105,100.00
210402	Тээвэр, шатахуун	90,000.00	90,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	90,500.00	131,100.00
210404	Ном, хэвлэл	-	67,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	282,700.00	251,500.00
2105	Нормативт зардал	77,400.00	77,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	77,400.00	77,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	588,200.00	288,200.00
210604	Урсгал засвар	588,200.00	288,200.00
2107	Томилолт, зочны зардал	70,000.00	-
210702	Дотоод албан томилолт	70,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,202,600.00	2,047,790.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	300,000.00	1,140,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	540,000.00
210807	Газрын төлбөр	362,600.00	367,290.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,851,846.52	3,851,845.08
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	3,851,846.52	3,851,845.08
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,215,701.49	33,517,416.98
2132	Бусад урсгал шилжүүлэг	300,000.00	27,781,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	27,481,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	300,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,915,701.49	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,915,701.49	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	5,735,816.98
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	5,735,816.98
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(2,019,946.52)	(3,851,845.08)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(2,019,946.52)	(3,851,845.08)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	113,846,725.00	137,217,396.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	100,000.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	100,000.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	100,000.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	100,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	113,746,725.00	137,217,396.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	112,245,100.00	136,613,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	112,245,100.00	136,613,200.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,501,625.00	604,196.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,501,625.00	604,196.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	113,769,725.00	137,217,396.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	113,769,725.00	137,217,396.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	103,052,398.51	103,095,783.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	68,998,405.85	69,476,925.00
210101	Үндсэн цалин	57,621,058.54	53,227,200.00
210102	Нэмэгдэл	9,049,682.31	14,794,370.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,327,665.00	1,455,355.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,914,692.66	9,320,068.02
210201	Тэтгэврийн даатгал	6,187,600.66	6,630,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	728,000.00	698,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	582,400.00	511,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	282,445.42	139,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,134,246.58	1,340,068.02
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,240,000.00	21,240,000.00
210301	Гэрэл, цахилгаан	348,000.00	1,798,900.00
210302	Түлш, халаалт	20,892,000.00	19,180,000.00
210303	Цэвэр, бохир ус	-	261,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	568,200.00	645,400.00

210401	Бичиг хэрэг	105,000.00	105,100.00
210402	Тээвэр, шатахуун	90,000.00	90,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	90,500.00	131,100.00
210404	Ном, хэвлэл	-	67,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	282,700.00	251,500.00
2105	Нормативд зардал	77,400.00	77,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	77,400.00	77,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	588,200.00	288,200.00
210604	Урсгал засвар	588,200.00	288,200.00
2107	Томилолт, зочны зардал	70,000.00	-
210702	Дотоод албан томилолт	70,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,595,500.00	2,047,790.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,815,500.00	1,140,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	540,000.00
210807	Газрын төлбөр	240,000.00	367,290.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,717,326.49	34,121,612.98
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,801,625.00	28,385,796.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	1,501,625.00	604,196.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	27,481,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	300,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	8,915,701.49	5,735,816.98
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,915,701.49	5,735,816.98
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>77,000.00</u>	≡
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	77,000.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	77,000.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	77,000.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	77,000.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(77,000.00)</u>	≡
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	129,007,587.00	9,198,971.36	(32,670,822.31)	105,535,736.05
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(3,851,845.08)	(3,851,845.08)
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	129,007,587.00	9,198,971.36	(36,522,667.39)	101,683,890.97

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Биелэлтийн хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	136,610,900.00	130,877,383.02	5,733,516.98	95.80%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	136,610,900.00	130,877,383.02	5,733,516.98	95.80%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	106,252,900.00	103,095,783.02	3,157,116.98	97.03%

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	69,794,600.00	69,476,925.00	317,675.00	99.54%
210101	Үндсэн цалин	63,345,400.00	53,227,200.00	10,118,200.00	84.03%
210102	Нэмэгдэл	4,588,000.00	14,794,370.00	(10,206,370.00)	322.46%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,861,200.00	1,455,355.00	405,845.00	78.19%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,423,200.00	9,320,068.02	103,131.98	98.91%
210201	Тэтгэврийн даатгал	6,631,000.00	6,630,500.00	500.00	99.99%
210202	Тэтгэмжийн даатгал	698,000.00	698,000.00	-	100.00%
210203	ҮОМШӨ-ний даатгал	558,400.00	511,900.00	46,500.00	91.67%
210204	Ажилгүйдлийн даатгал	139,600.00	139,600.00	-	100.00%
210205	Эрүүл мэндийн даатгал	1,396,200.00	1,340,068.02	56,131.98	95.98%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,977,100.00	21,240,000.00	2,737,100.00	88.58%
210301	Гэрэл, цахилгаан	2,158,800.00	1,798,900.00	359,900.00	83.33%
210302	Түлш, халаалт	20,892,500.00	19,180,000.00	1,712,500.00	91.80%
210303	Цэвэр, бохир ус	925,800.00	261,100.00	664,700.00	28.20%
2104	Хангамж, бараа материалын зардал	647,300.00	645,400.00	1,900.00	99.71%
210401	Бичиг хэрэг	105,100.00	105,100.00	-	100.00%
210402	Тээвэр, шатахуун	91,900.00	90,000.00	1,900.00	97.93%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	90,500.00	131,100.00	(40,600.00)	144.86%
210404	Ном, хэвлэл	77,100.00	67,700.00	9,400.00	87.81%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	282,700.00	251,500.00	31,200.00	88.96%
2105	Нормативт зардал	74,700.00	77,400.00	(2,700.00)	103.61%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	74,700.00	77,400.00	(2,700.00)	103.61%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	288,200.00	288,200.00	-	100.00%
210604	Урсгал засвар	288,200.00	288,200.00	-	100.00%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,047,800.00	2,047,790.00	10.00	100.00%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,140,500.00	1,140,500.00	-	100.00%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	540,000.00	-	100.00%
210807	Газрын төлбөр	367,300.00	367,290.00	10.00	100.00%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,358,000.00	27,781,600.00	2,576,400.00	91.51%
2132	Бусад урсгал шилжүүлэг	30,358,000.00	27,781,600.00	2,576,400.00	91.51%
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	30,058,000.00	27,481,600.00	2,576,400.00	91.43%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	300,000.00	-	100.00%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	136,613,300.00	130,877,383.02	5,735,916.98	95.80%
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	136,613,300.00	130,877,383.02	5,735,916.98	95.80%
132001	Орон нутгийн төсвөөс	136,613,300.00	130,877,383.02	5,735,916.98	95.80%

3.Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Орхон аймгийн Баян-Өндөр сумын Эгшиглэн соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд үндсэн хөрөнгөтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг “Мөнгө Нөөц Баялаг Аудит” ХХК-ийн аудитор З.Баттуяа гүйцэтгэж, хяналтыг гүйцэтгэгч талаас тус компанийн чанарын хяналтын менежер М.Бямбадорж, захирал Б.Байгал нар, захиалагч талаас Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер, Б.Эрдэнэ, газрын дарга тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхон аймгийн Баян-Өндөр сумын Эгшиглэн соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Мөнгө Нөөц Баялаг Аудит” ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 01 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Орхон аймгийн Баян-Өндөр сумын Эгшиглэн соёлын төв нь Баян-Өндөр сумын нутаг дэвсгэрт 1991 оны 01 дүгээр сарын 5-ний өдөр үүсгэн байгуулагдсан.

Тус соёлын төв нь хүүхэд залуучууд, иргэдэд зориулан үндэсний болон цахилгаан хөгжмийн дугуйлан, ардын бүжгийн дугуйлан, шатрын дугуйлан, клуб хичээллүүлдэг бөгөөд номын сангийн үйлчилгээ, интернэт, эх бэлтгэл хэвлэх, хувилах зэрэг үйлчилгээг тогтмол үзүүлдэг байна.

Баян-Өндөр сумын Эгшиглэн соёлын төв нь Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай багц хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын тухай багц хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Соёлын тухай хууль /2022 оны 01 дүгээр сарын 01-ээс дагаж мөрдөнө/ болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын тухай багц хууль, Нийгмийн даатгалын тухай багц хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль зэрэгт 2021 онд өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө багатай байна.

Номын фонд дансны дэлгэрэнгүй бүртгэлд нийт 4,771.5 мянган төгрөгийн ... ширхэг номыг нийт өртгөөр нь бүртгэж тоо ширхэг дээр нь 1 гэж бүртгэгдсэн байна. Нэг бүрчлэн дэлгэрэнгүй бүртгэлийг оруулаагүй байна. Мөн Номын фонд дансны дэлгэрэнгүй бүртгэл, тодруулга тайлан 27.3 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэгдсэн байна.

Бараа материалын дэлгэрэнгүй бүртгэл, тодруулга тайлан нийт 14,836.2 мянган төгрөгийн зөрүүтэй байсан ба нягтлан бодох бүртгэлийн программд дутуу оруулсан.

Байгууллагын бүтэц орон тоог нэмэгдүүлж 1,699.1 мянган төгрөг үндсэн цалин, 596.5 мянган төгрөгийн нэмэгдэл цалин, нийт 2,295.5 мянган төгрөгийн цалин олгосон байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь нягтлан бодох бүртгэлийн бодлого холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна.

Дотоод аудитын нэгж байхгүй. Харин Орхон аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу 2021 оны 09 дүгээр сарын 06-ны өдрөөс ажлын 14 хоногт багтаан дотоод аудитыг хийсэн байна. Уг ажлын хүрээнд 2021 оны

09 дүгээр сарын 21-ний 50/21 дугаар бүхий албан шаардлага 1, ажил сайжруулах 3 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Баян-Өндөр сумын Эгшиглэн соёлын төв нь ирүүлсэн зөвлөмжийн талаар арга хэмжээ авч зөрчлөө арилгаж ажилласан байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхон аймгийн Баян-Өндөр сумын Эгшиглэн Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр батлагдсан төсөв сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсвийн 136,613.2 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 2,732.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 1,912.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөлтийн үе шатны материаллаг байдлыг тогтоохдоо тайлант оны батлагдсан санхүүжилтийн дүнг суурь болгож авсан. Гүйцэтгэлийн үе шатанд суурь өөрчлөөгүй, гүйцэтгэлийн санхүүжилтийн дүнг суурь болгож авахад 114.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг бууруулах зөрүү үүссэн. Тиймээс ерөнхий материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатанд шинэчлэн тогтоосон материаллаг байдал 2,617.5 мянган төгрөг, гүйцэтгэлийн материаллаг байдал 1,832.3 мянган төгрөгөөр тогтоов.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Орхон аймгийн Баян-Өндөр сумын Эгшиглэн соёлын төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,851.8 мянган төгрөгөөр буюу 0.04 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгө, хуримтлагдсан үр дүн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
33	АВЛАГА	1,310.00	1,310.00	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	23,223.39	23,223.39	-	-
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	81,002.34	77,150.50	(3,851.85)	(0.05)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	105,535.74	101,683.89	(3,851.85)	(0.04)
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	129,007.59	129,007.59	-	-
512	Хуримтлагдсан үр дүн	(32,670.82)	(36,522.67)	(3,851.85)	0.12
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	9,198.97	9,198.97	-	-
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	105,535.74	101,683.89	(3,851.85)	(0.04)

Тус байгууллага нь Төрийн санд үндсэн санхүүжилтийн 1, нэмэлт санхүүжилтийн 1 данстай. Үндсэн санхүүжилтийн харилцах 100210035012 тоот дансаар 137,217.4 мянган төгрөгийн орлого орж, зарцуулагдсан байна. Нэмэлт санхүүжилтийн 100210035404 тоот дансанд гүйлгээ гараагүй.

- Авлага, бараа материалын дансанд өмнөх оноос өөрчлөлт ороогүй.

- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 0.05%-аар буюу 3,851.8 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь тайлант хугацааны элэгдэл болох 3,851.8 мянган төгрөг байна.
- Өр төлбөрийн дансанд өөрчлөлт ороогүй энэ онд тус байгууллага өр төлбөр, өглөг байхгүй.
- Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл өмнөх оноос 3,851.8 мянган төгрөгөөр буюу 0.12%-аар буурсан нь тайлант үеийн үр дүн 3,851.8 мянган төгрөгийн хэтрэлтийн нөлөөлөл юм. Төрийн өмчид өөрчлөлт ороогүй байна.

Хүснэгт 2. Орлогын үзүүлэлт /мянган төгрөг/

Орлогын нэр төрөл	2020 он	2021 он	Өөрчлөлт	Хувь
Татварын бус орлого	462.00	-	(462.00)	(1.00)
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	112,245.10	136,613.20	24,368.10	0.22
Нийт орлого	112,707.10	136,613.20	23,906.10	0.21

2021 онд тус байгууллагын нийт орлого өмнөх оноос 23,906.1 мянган төгрөгөөр буюу 21%-аар өссөн. Нэмэлт орлого байхгүй. Орон нутгийн төсвөөс авсан санхүүжилтийн орлогын дүнгээр өссөн байна.

Хүснэгт 4. Зардлын үзүүлэлт /мянган төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	Өөрчлөлт	Хувь
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	114,727,046.52	140,465,045.08	25,737,998.56	0.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	114,727,046.52	140,465,045.08	25,737,998.56	0.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	105,511,345.03	106,947,628.10	1,436,283.07	0.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	68,998,405.85	69,476,925.00	478,519.15	0.01
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,914,692.66	9,320,068.02	405,375.36	0.05
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,240,000.00	21,240,000.00	-	-
2104	Хангамж, бараа материалын зардал	568,200.00	645,400.00	77,200.00	0.14
2105	Нормативд зардал	77,400.00	77,400.00	-	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	588,200.00	288,200.00	(300,000.00)	(0.51)
2107	Томилолт, зочны зардал	70,000.00	-	(70,000.00)	(1.00)
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,202,600.00	2,047,790.00	845,190.00	0.70
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,851,846.52	3,851,845.08	(1.44)	(0.00)
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,215,701.49	33,517,416.98	24,301,715.49	2.64
2132	Бусад урсгал шилжүүлэг	300,000.00	27,781,600.00	27,481,600.00	91.61
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,915,701.49	-	(8,915,701.49)	(1.00)
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	5,735,816.98	5,735,816.98	-

Нийт зардал өмнөх оноос 22%-аар буюу 27,738.0 мянган төгрөгөөр өссөн байна. Тайлант он үйл ажиллагааны бус зардал гараагүй байна. Үйл ажиллагааны зардлын өсөлтийн нөлөөлөл нь:

- ✓ Бараа, ажил үйлчилгээний зардлын өсөлтөд цалин хөлс нэмэгдэл урамшуулал 0.01% буюу 478.5 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 0.05% буюу 405.4 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 0.14% буюу 77.2 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж 0.7% буюу 845.2 мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.
- ✓ Урсгал шилжүүлгийн зардлын өсөлт нь тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн өсөлттэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд бараа үйлчилгээний зардлыг 106,255.2 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлгийг 30,358.0 мянган төгрөгөөр, нийт 136,613.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Батлагдсан төсвийн зарлага болох 136,610.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн санхүүжилтээр санхүүжүүлэхээр баталжээ.

Тус байгууллагын 2021 оны төсөвт зардал, уг зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрт тодотгол хийгдээгүй. Дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгт 5-д үзүүлэв.

Хүснэгт 5. Төсвийн төлөвлөлтийн үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Төсвийн төлөвлөлт			2020/2021 оны зөрүү	Хувь
	2020 оны төсвийн төлөвлөгөө	2021 оны анхны батлагдсан төлөвлөгөө	2021 оны батлагдсан төлөвлөгөө		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл					
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	112,545.10	136,613.20	136,610.90	24,068.10	21.39%
УРСГАЛ ЗАРДАЛ	112,545.10	136,613.20	136,610.90	24,068.10	21.39%
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	112,245.10	106,255.20	106,252.90	(5,989.90)	-5.34%
Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	72,795.00	69,795.00	69,794.60	(3,000.00)	-4.12%
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,099.50	9,422.40	9,423.20	322.90	3.55%
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,104.40	24,344.40	23,977.10	(1,760.00)	-6.74%
Хангамж, бараа материалын зардал	647.30	647.30	647.30	-	0.00%
Нормативт зардал	77.40	77.40	74.70	-	0.00%
Эд хогшил, урсгал засварын зардал	488.20	288.20	288.20	(200.00)	-40.97%
Томилолт, зочны зардал	137.80	00.00	00.00	(137.80)	-100.00%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,772.90	1,680.50	2,047.80	(1,092.40)	-39.40%
Бараа үйлчилгээний бусад зардал	122.60	0.00	0.00	(122.60)	-100.00%
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	300.00	30,358.00	30,358.00	30,058.00	10019.33%
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	112,245.10	00.00	00.00	(112,245.10)	-100.00%
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	112,245.10	136,613.20	136,610.90	24,368.10	21.71%

Дээрх төсвийн төлөвлөлтийн өөрчлөлтөд үзүүлсэн нөлөөллийн хүчин зүйлүүдийг тайлбарлан авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал: 2021 онд уг зардлыг санхүүжүүлэх төсөв өмнөх оны батлагдсан төлөвлөгөөнөөс 4,12%-аар буюу 3,000.0 мянган төгрөгөөр буурсан байна.
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал: Өмнөх оноос 6.74%-аар буюу 1,760.0 мянган төгрөгөөр буурсан
- Хангамж, бараа материалын зардал: Өмнөх оноос өөрчлөлт ороогүй.
- Нормативт зардал: Өмнөх оноос өөрчлөлт ороогүй.
- Эд хогшил, урсгал засварын зардал: Өмнөх оноос 40.97%-аар буюу 200.0 мянган төгрөгөөр буурсан байна энэ онд засвар үйлчилгээ хийгээгүйтэй холбоотой байна.
- Томилолт, зочны зардал: Тайлант онд уг зардлыг төлөвлөөгүй.
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж: Өмнөх оноос 39.4%-аар буюу 1,092.4 мянган төгрөгөөр буурсан.
- Бараа үйлчилгээний бусад зардал: тайлант онд уг зардлыг төлөвлөөгүй байна.

2021 оны батлагдсан төлөвлөгөөг 2020 оны батлагдсан төлөвлөгөөтэй харьцуулахад нийт төсөв өссөн энэ нь урсгал шилжүүлгийн зардал буюу тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн өсөлттэй холбоотой байна. 2021 оны төсвийн төлөвлөлтөд нэмэлт зохицуулалт хийгдээгүй байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 136,610.9 мянган төгрөгийн төсөв баталж орон нутгийн төсвийн орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 130,877.4 мянган төгрөг буюу 95.8% байна. Төсвийн гүйцэтгэлийн хэлбэлзлийг дараах хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 6 Төсвийн гүйцэтгэлийн үзүүлэлт /мянган төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Биелэлтийн хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	136,610.90	130,877.38	(5,733.52)	95.80%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	136,610.90	130,877.38	(5,733.52)	95.80%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	106,252.90	103,095.78	(3,157.12)	97.03%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	69,794.60	69,476.93	(317.68)	99.54%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,423.20	9,320.07	(103.13)	98.91%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,977.10	21,240.00	(2,737.10)	88.58%
2104	Хангамж, бараа материалын зардал	647.30	645.40	(1.90)	99.71%
2105	Нормативт зардал	74.70	77.40	2.70	103.61%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	288.20	288.20	-	100.00%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,047.80	2,047.79	(0.01)	100.00%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,358.00	27,781.60	(2,576.40)	91.51%
2132	Бусад урсгал шилжүүлэг	30,358.00	27,781.60	(2,576.40)	91.51%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	136,613.30	130,877.38	(5,735.92)	95.80%
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	136,613.30	130,877.38	(5,735.92)	95.80%
132001	Орон нутгийн төсвөөс	136,613.30	130,877.38	(5,735.92)	95.80%

Тайлант онд цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлаас 317.8 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас 103.1 мянган төгрөгийн, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 2,737.1 мянган төгрөгийн, хангамж, бараа материалын зардлаас 1.9 мянган төгрөгийн хэмнэлт үүссэн байна. Үүний үр нөлөөгөөр төсөвт зардал 4.2%-аар хэмнэгджээ. Харин орон нутгийн төсвөөс тайлант онд гүйцэтгэлээр 136,613.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, үүнээс 130,877.3 мянган төгрөгийг урсгал үйл ажиллагаанд зарцуулж, 5,735.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2 дах заалтад “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд нэмэлт орлого ороогүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Аудитын хийх явцад аудитын баг холбогдох нотлох баримтыг саадгүй авч ашигласан бөгөөд тайлант оны санхүүгийн ажил гүйлгээ санхүүгийн тайланд толилуулсан мэдээллийн хүрээнд аудит хийгдсэн

3.8 Аудитын гол асуудал

Авлагын данстай холбоотой асуудал

Тус байгууллагын санхүүгийн тайланд 1,310.0 мянган төгрөгийн авлага бүртгэлтэй байна. Орхон аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу 2021 оны 09 дүгээр сарын 06-ны өдрөөс ажлын 14 хоногт багтаан дотоод аудитыг хийсэн байна. Уг ажлын хүрээнд 2021 оны 09 дүгээр сарын 21-ний 50/21 дугаар бүхий албан шаардлага 1 хүргүүлсэн байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны хэрэгжилтийг авч үзвэл тус байгууллага нь шилэн дансанд нийт 151 талбарт мэдээ оруулахаас 151 талбарт мэдээ оруулсан ба хэрэгжилт 100% байна. Улирал бүр аймгийн СХДАА-аас хяналт шалгалт хийгдэж, зөрчилгүй дүгнэгдсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төсвийн төлөвлөлт ба зохицуулалтын талаарх асуудал

Дээрх нөхцөл байдал болон энэ тайлангийн аудитын илрүүлэлт хэсэгт тусгагдсан асуудлуудаас бусад хууль тогтоомжид нийцээгүй зүйл бидэнд ажиглагдаагүй болно.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайланд түүврийн аудит хийж 111.5 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 1 зөвлөмж өгсөн байна. Хэрэгжилт 100% хувьтай байна.

Хүснэгт 7 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	111.5	1				
Албан шаардлага							
Зөвлөмж	1	105.0	1				
Нийт дүн	2	216.5	2				

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 21 тоот албан бичгээр Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэл хөтлөлт, ашиглалт, хадгалалт хамгаалалт, картжуулалт, үндсэн хөрөнгийн паспорт хөтлөлт, хөрөнгөд тавигдах дотоод хяналтын талаар дараагийн аудитаар анхаарал хандуулах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 17,159.0 мянган төгрөгийн материаллаг бус алдаа зөрчил илэрснээс, 2,295.5 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 14,863.5 мянган төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өгсөн. Илрүүлсэн алдаа, зөрчлийн дүн материаллаг байдлын түвшингээс давсан хэдий ч шинж чанарын хувьд материаллаг бус тайлагнал, бүртгэл хөтлөлт, дотоод хяналттай холбоотой алдаа зөрчил тул зөрчилгүй дүгнэлт саналыг аудиторын зүгээс танилцуулж байна.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаа байхгүй залруулга хийгдээгүй.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тавигдаагүй болно.

4.3 Албан шаардлага

1. Цалин хөлс тогтоолт, цалингийн тооцооллын талаар:

Оны эхэнд батлагдсан байгууллагын бүтэц орон тоог нэмэгдүүлж 1,699.1 мянган төгрөгийн үндсэн цалин, 596.5 мянган төгрөгийн нэмэгдэл цалин, нийт 2,295.5 мянган төгрөгийн цалин олгосон байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.2-т “Шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүйгээр цалингийн зардлыг хэмнэх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Номын фонд дансны дэлгэрэнгүй бүртгэлд 4,771.5 мянган төгрөгийн номыг нийт өртгөөр нь бүртгэж тоо ширхэг дээр нь 1 гэж бүртгэгдсэн байна. Нэг бүрчлэн дэлгэрэнгүй бүртгэлийг оруулаагүй байна. Мөн номын фонд дансны тодруулга тайлан, дэлгэрэнгүй бүртгэл нь 27.3 мянган төгрөгөөр зөрүүтэй дутуу бүртгэгдсэн байна. Энэ нь Сангийн сайдын 2018 оны 100 дугаар тушаал “Маягт аргачлал батлах тухай”-ын үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэл ҮХ-1-ийг зөрчиж толилуулга, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Хөрөнгүүдийг нэр төрөл тус бүрээр нь нэг бүрчлэн холбогдох журамд нийцүүлэн бүртгэх.

2. Хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Тусгай зориулалтын материал, аж ахуйн материалын дэлгэрэнгүй бүртгэл, тодруулга тайлан 14,836.2 мянган төгрөгийн зөрүүтэй байна. Энэ нь Сангийн сайдын 2018 оны 100

Орхон аймгийн Баян-Өндөр сумын Эгшиглэн Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

дугаар тушаал "Маягт аргачлал батлах тухай"-ын бараа материал БМО-1-ыг зөрчиж, толилуулга, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

CTS программд тухайн хөрөнгүүдийг дэлгэрэнгүй бүртгэлд нэр төрөл тус бүрээр нь нэг бүрчлэн оруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Залруулга		Төлбөрийн акт		Үүнээс Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Орхон аймгийн Баян-Өндөр сумын Эгшиглэн соёлын төв	3	17,159.0	-	-	-	-	1	2,295.5	2	14,836.2

АУДИТЫН ТАЙЛАНГ

БЭЛТГЭСЭН:

"МӨНГӨ НӨӨЦ БАЯЛАГ АУДИТ" ХХК-ийн

АУДИТОР:

ХЯНАСАН:

ЧАНАРЫН ХЯНАЛТЫН МЕНЕЖЕР
ЗАХИРАЛ

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
АУДИТЫН МЕНЕЖЕР

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР:

З.БАТТУЯА Огноо: 2022.02.24

М.БЯМБАДОРЖ
Б.БАЙГАЛ

Огноо: 2/25
Огноо:

Б.ЭРДЭНЭ

Огноо:

Ц.НАРМАНДАХ

Огноо:



8117143690
ФАА0073-9042805

